

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 02 дугаар сарын 17

Улаанбаатар хот

ДЦД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай 01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагуудаас санал авч, нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж ажиллах.				
1.	Нийслэлийн Засаг даргын “2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай 2022 оны 01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, албадаас нэгдсэн төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн авч, 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 3/277 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны Удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ХОЁР: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хариуцсан ажлын чиглэлээр нийслэлийн иргэдэд боловсрол мэдлэг олгох, соёлыг төлөвшүүлэх, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах, эрүүл мэндийг анхаарах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрэхүйц ажлыг санаачлан зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллах.				
2.	<p>- Дүүргийн харьяа их дээд сургууль, МСҮТ, Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг танхимын хэлбэрээр явуулах болсонтой холбогдуулан Коронавируст (Ковид-19)-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналт шалгалтын ажлыг нийт 84 байгууллагад 2022 оны 2 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд зохион байгуулан зөвлөн тусалж ажилласан.</p> <p>- Ажил идэвхтэй хайж хандсан иргэдийг бүртгэн авч ажил олгогч байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг хүсэл сонирхол, дадлага туршлага, ур чадварыг нь харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн тохирч тэнцэх ажлын байранд холбон зуучлах үйл ажиллагаа явуулж, сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 105, ажил идэвхтэй хайж буй 820 иргэнийг бүртгэж, нийт 48 иргэнийг ажлын байранд зуучлан, 18 шинэ ажлын байрыг бүртгэсэн байна.</p> <p>- Ковид 19 халдварын Омикрон хувилбарын нөхцөл байдалтай холбогдуулан дүүргийн 13 дугаар хороонд байрлах Хайлааст амбулаторийг түшиглэн 50 ор бүхий хэвтүүлэн эмчлэх эмнэлгийг нээн ажиллуулж байгаагаас гадна ковидын халдвар аван эмчлэгдэж буй иргэдэд зориулан Ковидын амбулаторийг давхар нээн ажиллуулж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70

	- Бүх шатны боловсролын байгууллагын хичээл сургалтын үйл ажиллагаа 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 100 хувь танхимаар эхлэх болсонтой холбогдуулан 2021-2022 оны хичээлийн жилд үргэлжлэн суралцах 3-5 настай хүүхдүүдийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан тодорхой цагийн хуваарь гарган 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 13-ны өдрүүдэд нийт 264 цэцэрлэгт 45 явуулын шинжилгээний лабораторийг ажиллуулж 4113 хүүхдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж ажиллалаа.			
Үүрэг, даалгавар ГУРАВ: 2022 онд Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулах “Хариуцлагын гэрээ” байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах.				
3.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу дүүргийн Засаг даргын дэргэдэх 20 хэлтэс, албадын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн авсан ба төлөвлөгөөг хянуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: 2022 онд Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг бүх шатанд эрчимжүүлж ажиллах.				
4.	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2022 онд шинээр хэрэгжих 87,035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 58 төсөл, арга хэмжээ, 2021-2022 он дамжин хэрэгжих 101,273.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 112 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Нийт 170 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцыг 14 хоног тутам шинэчилж, шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар ТАВ: Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлсэн захирамж гарснаас ажлын 3 хоногт үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай иж бүрэн материалыг судалж, захиалагч байгууллагатай хамтран ажиллах.				
5.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/140 дүгээр захирамжаар дүүргийн Засаг даргад 600,000,000 /зургаан зуун сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй 3 /гурав/ төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн. Дээрх захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/50 дугаар захирамж гаргаж үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нутгийн захиргааны байгууллагууд дотооддоо халдвараас урьдчилан сэргийлж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж, дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж ажиллах.				
6.	Засаг даргын Тамгын газрын байранд өөрсдийн нөөц бололцоогоор өдөрт 3 удаа ариутгал халдваргүйтгэл хийж, мөн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр 1-5 давхрын өрөө тасалгаа, коридор, шат, хогийн сав зэрэг нийт 1260 м.кв талбайд клорсепт 17 бодисын 0.05%-ийн уусмалаар урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийлгэсэн. Халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг мөрдөн ажиллаж шинж тэмдэг илэрсэн ажилтан албан хаагчдыг ажлын байранд нэвтрүүлэхгүйгээр түргэвчилсэн тестээр	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

	шинжилгээ авч эерэг гарсан тохиолдолд харьяа өрхийн эмнэлэг рүү цаг алдалгүй шилжүүлэн ажиллаж байна.			
Үүрэг, даалгавар ДОЛОО: Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажиллах.				
7.	<p>2022 онд дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 110 өргөдөл ирснээс 101 -ийг шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа 9 өргөдөл хүсэлт байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ иргэнд хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Иргэний талд шийдвэрлэсэн 66 ✓ Боломжгүй тухай хариу өгсөн 16 ✓ Бусад хариу өгсөн 17, Үүнээс: ✓ Программ мессежээр 24 ✓ Программ мессеж утсаар 70 ✓ Программ мессеж албан бичгээр 7 байна. <p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 21 цаг 19 минут байна. Өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ өдөртөө багтаан хүлээн авах, явцын тэмдэглэл 10 хоног дутам хөтөлж хэвших, хууль зүйн үндэслэлтэй эцэслэн шийдвэрлэх, иргэнд заавал хуулийн хугацаанд нь хариу өгч хэвших зэрэг зөвлөмжийг хэлтэс албадад хүргүүлэн ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар НАЙМ: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” нь шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр удирдлага арга зүйгээр хангаж, сургалт зохион байгуулж ажиллах.				
8.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх хүрээний байгууллага, УТҮГ, ОНӨТҮГ-ын удирдлага, Албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдад зориулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн 2022 оны сургалтын дэд төлөвлөгөө”-г 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн танилцуулга, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын танилцуулга, удирдлагын хүлээх үүрэг, хэрэгжилт, “Хэвлэмэл хуудасны нэршил, хаягийн бичвэр өөрчлөх” “Захирамжлалын баримтаар цахим архив үүсгэх”, https://erp.ulaanbaatar.mn/ “Archive Edoc системийн ашиглалт”, шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан https://erp.ulaanbaatar.mn/, e doc системийн ашиглалт”, Архив албан хэрэг хөтлөлт, MNS 5140-1:2021; MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021 Стандарт зэрэг сургалтыг шат дараалалтай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ЕС: Олон нийтийн амгалан тайван байдал, нийгмийн хэв журам, гэмт хэрэг зөрчил болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих ажлыг эрчимжүүлэн ажиллах.				

9.	<p>Дүүрэг дэх Цагдаагийн газар: Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 10 чиглэлд 20 алба хаагч явган эргүүлд, авто эргүүлийн 10 автомашинтай 20 албан хаагч 24 цагаар хяналт тавин ажиллаж байна. Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчил тогтмол бүртгэгдэж байгаатай холбогдуулан “Халаас” арга хэмжээг зохион байгуулж, энгийн хувцастай алба хаагчид гэмт хэрэг, зөрчил бүртгэгдэж байгаа газруудад хяналт тавин ажиллаж байна. Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Халаасны хулгайчаас сэрэмжил” видео мэдээлэл бэлтгэж иргэд олон нийтэд сэрэмжлүүлэг хүргэсэн, мөн хулгайлах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 төрлийн постер, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 зурагт хуудас бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан.</p> <p>Хүүхдийг ахуйн хүрээний осол гэмтэл болон гадна орчны осол аюул, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр 5 зурагт хуудас бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан.</p> <p>Ахуйн хүрээнд байнга архидан согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 26 хүнийг шүүхээр арга хэмжээ тооцуулахаар материалыг хүргүүлэн, 7-30 хоногоор баривчлах шийтгэл оногдуулж ажилласан. Мөн Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран “Хамтарсан хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байсан айл өрхийг эргэн хянах чиглэлээр судалгаа гаргаж ажиллаж байна.</p> <p>Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Улаанбаатар Эрдэм дээд сургуулийн гадаад 35 оюутанд “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Хулгайлах” гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.</p> <p>“Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох”, Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41 дүгээр зүйл “Хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтоох” гэсний дагуу захиргааны хяналтад байгаа 10 хүн байгаагаас 9 хүнтэй нь уулзаж яриа таниулга хийж баталгаа бичүүлэн авсан. Мөн архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, зөрчилд холбогдсон 35 иргэн “Архины хор хөнөөл”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр сургалт орж, яриа таниулга хийж ажилласан.</p> <p>Онцгой байдлын хэлтэс: Гамшиг осол болон гал түймрийн хяналт шалгалтын чиглэлээр: Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний 15, иргэний орон сууцны 12, нийтийн хоол, ресторан, караоке 8, хүнсний дэлгүүр, худалдааны 15, нийт 50 барилга байгууламжид Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймрийн</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
----	---	---	---------------------------------------	-----

улсын хяналтын дүрэм, галын аюулгүйн байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт техникийн нормативыг үндэслэн хэрэгжилтийг шалгахад 213 зөрчил дутагдал илрүүлэн засагдах боломжтой 45 зөрчил буюу 21 хувийг газар дээр нь арилгуулан, бусад 168 зөрчил буюу 79 хувийг арилгуулах талаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-21, мэдэгдэл-28, танилцуулга-1 бичиж холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтын чиглэлээр: Болзошгүй гамшиг осол, гал түймэр, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах 2 удаагийн сургалтыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын нийт 298 ажилтан, алба хаагчид зохион байгуулан ажилласан. Мөн дүүргийн гэр хорооллын 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрийн айл өрхийн пийшин зуухны аюулгүй байдлыг хангах "Аюулгүй галлагаа" нэгдсэн арга хэмжээг Онцгой байдлын хэлтсийн 2 автомашин, давхардсан тоогоор 340 алба хаагч эрсдэл бүхий 2814 айл өрхөд гал түймэр болон угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгч, 2785 санамж сэрэмжлүүлгийн материал тараах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ХАНГАЙ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.НАВЧАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДОЛГОРМАА